

**БАТЛАВ:**

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ  
ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ДАРГА

 Г.ЦОГТСАЙХАН

**"ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН"-ГИЙН ЦАХИМ СИСТЕМ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 07 сарын 25-ны өдөр

№03

Улаанбаатар хот

<b>Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>• УИХ-ын 2021 Оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 6.1 дэх хэсэг;</li> <li>• Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт;</li> </ul>
<b>Зөвлөх үйлчилгээний зорилго</b>	<p>Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх үйл ажиллагааны болон санхүү, эдийн засгийн мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэх, албан тушаал, инженер техникийн ажилчид, ус хангамж, цэвэрлэх байгууламжийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмж, ажлын байрыг бүрэн тусгаж хяналт, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх зорилготой тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн онлайн бүртгэлийн цахим системийг хөгжүүлж, нэвтрүүлэх зорилготой.</p>
<b>Зөвлөх үйлчилгээний үр дүн</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны мэдээллийг боловсруулах, хянах, тоон мэдээллийг тухайн агшинд бүрдүүлэх, усны үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэх ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн байна.</li> <li>2. УХАТ-ын салбарын цахим үйлчилгээ чанартай, тасралтгүй, шуурхай, баталгаатай болно.</li> <li>3. Салбарын хэмжээний өгөгдлүүдийг нэгтгэсэн мэдээллийн сан үүснэ</li> <li>4. Дата мэдээллийн эх үүсвэрүүдээс эксэл байдлаар авах бус шууд интеграц хийж /real time/ бодит цагийн горимоор мэдээллийг шуурхай авдаг байна.</li> <li>5. Удирдлагуудад боловсруулан гаргадад дашбоард, чартууд системээс авто гардаг байна. Онлайн орчинд хүссэн үедээ нэвтрэн мэдээлэл авах боломжтой байна</li> <li>6. Чарт, дашбоард, хүснэгтэн байдлаар мэдээлүүдийг боловсруулдаг байх ба бүхий л тайлан мэдээ нь динамик буюу эцсийн хэрэглэгчид өөрсдөө хийх боломжтой байна. Хөгжүүлэгч компанийн хамааралгүйгээр тайлан мэдээгээ боловсруулах боломжтой байна</li> </ol>
<b>Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ</b>	<p>Тус Зохицуулах хорооноос олгосон ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дээр дурдсан мэдээллийн сангийн зорилгын хүрээнд тухайн үйл ажиллагаатай холбогдсон цахим системийг байгуулах, хөгжүүлэх ажлын хүрээг хамарна.</p>

<p><b>Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Кибер аюулгүй байдлын тухай хууль;</li> <li>• Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;</li> <li>• Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;</li> <li>• Барилгын тухай хууль;</li> <li>• Орон сууцны тухай хууль;</li> <li>• Бусад холбогдох хуулиуд.</li> </ul>
<p><b>Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх багт тавигдах шаардлага</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан 10-аас багагүй жилийн туршлагатай байх;</li> <li>2. Ахлах программ хөгжүүлэгч нь 10 ба түүнээс дээш жил ажилласан байх;</li> <li>3. Программ хангамжийн инженер 5 ба түүнээс дээш жил ажилласан байх;</li> <li>4. Системийн шинжээч 2 ба түүнээс дээш жил ажилласан байх;</li> <li>5. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, түүний шат дамжлагын талаар ойлголт, мэдлэгтэй байх;</li> </ol>
<p><b>Мэдээллийн сан боловсруулалтын шаардлага</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. “Төрийн байгууллагуудын цахим хуудсанд тавигдах шаардлагын стандарт” (MNS ISO 8072:2010)-д үндэслэн, хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар, өргөн агуулгатай байх зарчмыг баримталж, техникийн болон физик хүчин зүйлүүдээс аль болох хамааралгүй динамик байх;</li> <li>2. Иргэд, олон нийтээс судалгаа авах, судалгааны үр дүнг график дүрслэлээр харуулах, статистик, тоо баримт, тайланг нэгтгэн гаргадаг байх.</li> </ol>
<p><b>Техникийн шаардлага</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Мэдээллийн сангийн программ хангамжийн бүх бүрдэл хэсэг нь нэг ижил дизайны шийдэлтэй, хэрэглэхэд хялбар, энгийн ойлгомжтой интерфэйс, дизайнтай байх;</li> <li>2. Мэдээлэл нь улс, бүс, аймаг, сум, хэсэгчилсэн байдлаар орон зайн болон атрибут мэдээллээр хайлт хийх боломжтой байх;</li> <li>3. Таблет болон гар утасны төхөөрөмжүүд дээр саадгүй ажилладаг байх;</li> <li>4. Харагдах байдал, өгөгдлийн сангийн хүрээнд засвар оруулах, цэсийн байршил солих, нэмэх, хасах боломжоор хангагдсан уян хатан байх;</li> <li>5. Сервер ба сүлжээний хүчин чадлын хамгийн бага түвшинд ашигладаг байх;</li> <li>6. Захиалагчийн бүрдүүлсэн техник хангамж, системийн орчинд дрограммын техникийн болон сүлжээний доголдол, алдаа гарсны дараа дахин сэргээх боломжтой байх;</li> <li>7. Архивлах, нөөцлөх боломжтой байх;</li> <li>8. Хэрэглэгчдийн эрх, хуулийн этгээдийн бүртгэлийг ХУР, ДАН системээр дамжуулан хийх ба хэрэглэгчдэд мессэж очдог, системтэй холбогдсон байх;</li> <li>9. Програмын интерфэйс хэл: Монгол, Англи</li> <li>10.Тэмдэгтийн стандарт: UNICODE UTF-8</li> <li>11.Програмын ажиллах орчин: RHEL7 /distro/ түүнээс дээш</li> <li>12.Мэдээллийн сан: MySql, noSQL</li> <li>13.Програмчлалын хэл: Java, JavaScript нэмэлтээр, React, HTML, Backend – Spring Boot</li> <li>14.Хэрэглэгчийн вэб хөтөч – Google Chrome 23, Mozilla Firefox 17, Internet Explorer 10, Opera 12, Apple Safari 6 хувилбарууд ба түүнээс дээш 10, Opera 12, Apple Safari 6 хувилбарууд ба түүнээс дээш</li> <li>15.Хэрэглэгчийн гарын авлагатай байх;</li> </ol>

	<p>16.Мэдээллийн сангийн бүтэц, диаграмм, кодчиллол доторх тайлбарыг хийх.</p> <p>17.Мэдээллийн сангийн хүснэгтүүдийн уялдаа холбоог сайн зохион байгуулж, sharding, index зэрэг мэдээллийн сангийн давуу боломжуудыг түлхүү ашиглаж table-ийн бүтцийг гаргасан байх;</p> <p>18.Хөгжүүлэлтэд ашигласан нэмэлт программ хангамж, сангууд нь хамгийн багадаа 5 жил тасралтгүй, саадгүй ажилладаг байх;</p> <p>19.Хэрэглэгчийн хандалтыг бүртгэх, хэрэглэгчийг бүх түвшинд тохируулах боломжтой байх;</p> <p>20.Төслийн боловсруулалтын явцад холбогдох инженер техникийн ажилтнуудад сургалт зохион байгуулах, нийт албан хаагчдын дунд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах.</p> <p>21.Ашиглалтад орсны дараа гүйцэтгэгч хуулийн этгээдээс хараат бус байх;</p> <p>22.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/66 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Мэдээллийн систем ашиглах журам”-ын Хавсралт 5-ын 1-д заасан шаардлагуудыг хангасан байх.</p> <p>23.Дээр дурдсан шаардлагуудад тусгагдаагүй бусад нийтлэг шаардлагуудыг хангасан байх.</p>
<p><b>Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны чиглэлээр хийгдэх ажилд тавигдах шаардлага</b></p>	<p>1. Дараах холбогдох системүүдтэй API солилцох боломжтой байх; Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын салбарын мэдээллийн системээс холбогдох мэргэжлийн үнэмлэх, диплом лавлагаа хардаг байх;</li> <li>• Салбарын санхүү, эдийн засаг, үнэ тарифын мэдээллийн сантай уялдсан байх;</li> <li>• “WDMS2.0-Бохир зөөврийн дэд систем”-тэй холбогдож ажиллах боломжтой байх;</li> <li>• Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн систем <a href="http://www.license.mn">www.license.mn</a>-тай уялдсан байх;</li> <li>• Барилгын нэгдсэн мэдээллийн систем <a href="http://mcis.gov.mn">mcis.gov.mn</a>-тэй уялдсан байх;</li> <li>• Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны мэдээллийн систем <a href="http://www.mcsud.gov.mn">www.mcsud.gov.mn</a>-тэй уялдсан байх;</li> <li>• Усны мэдээллийн нэгдсэн систем <a href="http://www.ewater.mn">www.ewater.mn</a>-тэй уялдсан байх;</li> <li>• UB engineering систэй уялдсан байх;</li> <li>• Захиагалчийн <a href="http://www.wsrc.gov.mn">www.wsrc.gov.mn</a> цахим хуудасны нүүр хуудсан дээр “Статистик”, “Нээлттэй өгөгдөл” цэсүүд үүсгэж холболтыг хийх;</li> </ul> <p>2. Анхан шатны бүртгэлүүдийг баталсан маягтын дагуу бүртгэл хөтөлдөг байх;</p> <p>3. Бүх бүртгэлийн түүхчилсэн сан хөтөлдөг байх;</p> <p>4. Анхан шатны бүртгэлүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийн сантай холбож мэдээлэл оруулах, солилцох боломжтой байх;</p> <p>5. Байгууллага шинээр бүртгэх цонхонд үндсэн мэдээллийн баазаас автоматаар өмнө бүртгэгдсэн эсэхийг шалгах товчлууртай байх;</p> <p>6. Тайлангийн иж бүрэн дэд системтэй байх /батлагдсан маягтын дагуу/;</p>

	<ol style="list-style-type: none"> <li>7. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө автоматаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тус Зохицуулах хорооны хариуцсан мэргэжилтэнд дохио өгдөг байх;</li> <li>8. Тусгай зөвшөөрлийн болон зөвшөөрөл эзэмшигчийн нэр оруулах талбарт давхар дарагдсан зай (space) эсвэл том, жижиг нэгжийн нэр (ХХк, хк, ХХК) зэргийг програм өөрөө засдаг байх;</li> <li>9. Тайлан мэдээг заасан хугацаанаас хойш бөглөсөн эсэхийг харах боломжтой байх /хугацаа дуусахад автоматаар бөглөх боломжгүй болох, дахин 3-5 хоногийн хугацаатай эрх авах/;</li> <li>10. Заавал оруулах мэдээлэлд улаанаар тусгай тэмдэглэгээ хийж өгөх;</li> <li>11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч (ТЗЭ) нь зөвхөн өөрийн хэрэглэгчийн нэр, нууц кодоор нэвтрэн орж холбогдох мэдээллүүдийг заагдсан хугацаанд оруулах, засварлах эрхтэй байна. Зөвхөн заагдсан хугацаанд л засвар оруулахаар байх;</li> <li>12. ТЗЭ мэдээлэл оруулах хэсэг бүрт ? тэмдэг дархад дэлгэрэнгүй тайлбартай байна. Энэ мэдээлэл Mouse Over горимоор ажилладаг байх;</li> <li>13. Тус Зохицуулах хорооны нэвтрэх эрх бүхий ажилтан, албан хаагчид тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг харах боломжтой байх /Засвар оруулах эрх бүхий албан хаагч нь итгэмжлэгдсэн албан тушаалтан байх/;</li> <li>14. Програмаас болон интернэт хувилбараас эрх бүхий хэрэглэгч бүх төрлийн мэдээлэлийг EXCEL програм руу хадгалдаг байх;</li> <li>15. Тайлан мэдээний хүснэгт тус бүрийг бүлэглэн шүүж, нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хэмжээнд харах боломжтой байх; Жишээ нь: Тайлан мэдээний зөвхөн хүснэгт №13-ийг нийт ТЗЭ-дийн хэмжээнд харах, хугацаа нь дуусаж буй ТЗЭ-дийн мэдээллийг харах гэх мэт.</li> <li>16. Бүх мэдээллүүдийг ялгаж харах боломжтой байх /жишээ нь нийт ТЗЭ-чдийн зөврийн ус түгээх байрны тоог харах боломжтой байх, бас 10-20 жилийн насжилттай цайрдсан ган шугам сүлжээний урт, байрлалыг Улаанбаатар хотоор харах боломжтой байх, мөн Хан-Уул дүүргийн 3-р хорооны бүх орон сууцны мэдээллүүдийг ялгаж харах боломжтой байх гэх мэт/;</li> <li>17. Тайлан мэдээний хүснэгтийг бөглөснөөр тухайн ТЗЭ-ийн гүйцэтгэлийн үзүүлэлт автоматаар бодогддог байх;</li> <li>18. Хэвлэх цаасны хэмжээг сонгож хэвтээ болон босоо байдлаар хэвлэх боломжтой болон үсгийн фондын хэмжээг сонгох боломжтой байх;</li> <li>19. Тайлан мэдээний бүлэглэж гаргасан үр дүнг pdf буюу засвар хийх боломжгүй файл болгон хадгалах боломжтой байх;</li> <li>20. Мэдээллийн санд бүртгэлтэй инженер, техникийн ажилтнууд өөр аж ахуйн нэгж, байгууллагууд дээр давхцаж байгааг харах боломжтой байх;</li> <li>21. Орон сууцны байрны давхцыг харах боломжтой байх; /мэдээллийн сангаас шууд хайлт хийж урьд нь бүртгэгдсэн гэсэн хариу гарах эсвэл сигнал өгөх/;</li> <li>22. Гарын авлага Монгол хэлээр байх;</li> </ol>
<b>Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүү, эдийн засгийн чиглэлээр</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Харьяа байгууллагын цахим хуудаснаас вэб сервисээр мэдээлэл дуудаж харуулах боломжтой байх.</li> </ol>

<p><b>хийгдэх ажилд тавигдах шаардлага</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>2. Салбарын санхүү, эдийн засгийн бүртгэлийн маягтуудыг системд оруулж цахимжуулна.</li> <li>3. Маягтыг үүсгэх зааварчилгааг өгч, сургалт орно.</li> <li>4. Салбарын санхүү, эдийн засгийн бүх маягтыг үүсгэх, өөрчлөх, засварлах боломжтой байх ба маягтыг хийхдээ гүйцэтгэгч буюу хөгжүүлэгч компанийн оролцоогүйгээр баяжуулах боломжтой байхаар хөгжүүлэлтийг гүйцэтгэх.</li> <li>5. Өмнөх санхүү, эдийн засгийн эксэл файл дээрх дата мэдээллүүдийг шууд импорт хийж оруулах, тухайн бүртгэлийг цаашид эксэл дээр биш систем дээр хөтлөх боломжтой байх. Бүртгэл хийх ажилчдын эрх үүрийн тохиргоо, ажлын урсгал хийх боломжтой байх.</li> <li>6. Тоон мэдээлэл үнэн зөв эсэхийг баталгаажуулах ажлын урсгалыг маягт болгон дээр тохируулах боломжтой байх</li> <li>7. Хэрэглэгчийн эрх үүргээс хамаараад зөвхөн өөрсдийн бүртгэсэн мэдээллийг харах, засварлах эрхийн зохицуулалт хийх боломжтой байх;</li> <li>8. Салбарын мастер дата санг үүсгэх боломжтой байх ба маягтуудад тус мастер датаг ашиглан бүртгэлжүүлэлтийг хийх боломжтой байх;</li> <li>9. Салбарын мета дата санг үүсгэсэн байх ба маягт бүр дээр мета датаг бөглөж бүртгэлжүүлэх боломжтой байх;</li> <li>10. Зурган болон видео гэх мэт дижитал хэлбэртэй дата мэдээллүүдийг нэгдсэн санд харуулах боломжтой байх;</li> <li>11. Орон зайд тулгуурласан датаг бүртгэлжүүлж координат байршил бүртгэсэн мэдээллүүдийг харуулдаг байх;</li> <li>12. Бүртгэсэн маягт тус бүрээр сервис гаргаж өгөх боломжтой байх. Сервисийн дагуу өөр газруудад мэдээллээ шэйрлэх боломжтой байх;</li> <li>13. Цэвэр бохир усны үйлчилгээний тарифын санал, өртгийн тооцоолол, батлагдсан тарифын мэдээллийн дэд систем үүсгэх боломжтой байх;</li> <li>14. Мэдээллийн дашбоард, чартууд системээс хугацааны интервалаар автоматаар гардаг байх;</li> <li>15. Чарт, дашбоард, хүснэгтэн байдлаар мэдээллүүдийг боловсруулах бөгөөд бүхий л тайлан мэдээ нь динамик буюу эцсийн хэрэглэгчид өөрсдөө хийх боломжтой байна. Хөгжүүлэгч компанийн хамааралгүйгээр тайлан мэдээгээ боловсруулах боломжтой байх;</li> <li>16. Салбарын тоон мэдээлэл усны баланс, олборлосон, борлуулсан ус, усны алдагдал, тоолууржилтын хувь зэрэг мэдээллүүдийг Үндэсний статистикийн хорооны дата өгөгдөлтэй солилцдог байх.</li> </ol>
<p><b>Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх үе шат</b></p>	<p>Үйлчилгээний төлөвлөлт, бэлтгэл үе;</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу веб систем архитектур, дизайныг гаргаж, гүйцэтгэгчтэй зөвшилцөж, батлуулна.</li> <li>2. Батлагдсан архитектурын дагуу системийн хөгжүүлэлт хийнэ.</li> <li>3. Хөгжүүлэлт хийгдсэний дараа тест хувилбарыг нэвтрүүлнэ.</li> <li>4. Ажлын хэсгийн гишүүдээс тест хувилбар дээр гаргасан шүүмжийн дагуу засвар хийнэ.</li> <li>5. Ажлын хэсгийн гишүүдээс санал авч шаардлага хангасан үед системийг захиалагч талд хүлээлгэн өгнө.</li> <li>6. Байгууллагын хэмжээнд нэвтрүүлэлт, сургалтыг хийнэ.</li> <li>7. Тайлагнах, баталгаажуулах үе</li> </ol>
<p><b>Хүлээлгэж өгөх ажлын иж бүрдэл</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Ажлын тайлан /Тус бүр цаасан болон цахим хэлбэрээр/</li> </ol>

	<ul style="list-style-type: none"> <li>• Эхлэлийн тайлан: Ажил эхэлснээс хойш 14 хоногийн дотор хийгдсэн ажлын тайлан, техникийн баримт бичгийг боловсруулж өгнө.</li> <li>• Явцын тайлан: Ажил эхэлснээс хойш 45 хоногийн дотор хийгдсэн ажлын тайлан, техникийн баримт бичгийг боловсруулж өгнө.</li> <li>• Гүйцэтгэлийн тайлан: Цахим системийн хөгжүүлэлтийн явцад 7 хоног тутам систем хөгжүүлэлтийн ажил Ажлын даавгаврын дагуу явагдаж байгаа эсэх талаар тайланг боловсруулж өгнө.</li> <li>• Эцсийн тайлан: Цахим системийг бүрэн хөгжүүлж, туршилт, нэвтрүүлэлтийг бүрэн хийж, эцсийн тайланг боловсруулж өгнө.</li> </ul> <ol style="list-style-type: none"> <li>2. Системийн архитектурын зураг</li> <li>3. Программ хангамжийн эцсийн хувилбарыг хүлээлгэн өгөх;</li> <li>4. Програмын ажил бүрэн дууссаны дараа цаашид өргөжүүлэх, өөрчлөх бололцоог хангах үүднээс Зохицуулах хороонд эх кодыг хүлээлгэн өгөх;</li> <li>5. Тоон мэдээлэл, систем ашиглах гарын авлага /CD болон DVD/</li> <li>6. Техникийн даалгаварт байгаа шаардлагын дагуу хийгдсэн програмд 1 жилийн баталгаа өгөх;</li> <li>7. Баталгаат хугацаанд ямар төрлийн нэмэлт ажил, засвар, үйлчилгээ хийх талаар тодорхой заах;</li> <li>8. Гэрээ дүгнэсэн акт, бусад материал.</li> </ol>
<b>Шаардагдах зардлын тооцоолол</b>	200,000,000 төгрөг
<b>Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хугацаа</b>	Гэрээ байгуулснаас хойш 6 сар
<b>Захиалагч байгууллага</b>	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо
<b>Гүйцэтгэх байгууллага</b>	Төсөл гүйцэтгэх чанарын үнэлгээгээрээ хамгийн сайн үнэлэгдсэн бөгөөд төсөвт багтсан үнийн санал өгч хамгийн сайн үнэлэгдсэн хуулийн этгээд
<b>Сургалт зохион байгуулах багт тавигдах шаардлага</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Систем нэвтрүүлэлтийн чиглэлээр сургалт зохион байгуулсан туршлагатай байх;</li> <li>2. Сургалтын материал, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;</li> <li>3. Сургалт зөвлөгөөний тараах материал, видео хичээл, мэдээллийн хуудас, ном, гарын авлагаар хангах боломжтой байх;</li> <li>4. Салбарын нийт ажилтнуудад сургалт, зөвлөгөө өгч, системийн ашиглалтад хяналт тавих.</li> </ol>
<b>Зөвлөх үйлчилгээний онцгой нөхцөл</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хорооны ажилтнуудад дата менежментийн талаар сургалт орж, хэрэгжилтэд хяналт тавих</li> <li>2. Тайлан, чартуудын мета датаг боловсруулахад зөвлөгөө өгөх</li> </ol>

--- о О о ---